



1997 он 12 сар 01 өдөр

№ 327

Улаанбаатар хот

Гадаадад сургах тухай

ТУШААХ НЬ:

1. Лүндэнгийн Оюунчимэгийг хүнсний технологийн, Пүрэвжавын Батхишигийг төрийн удирдлагын, Гантөмөрийн Эрдэнэчимэгийг эмнэлгийн техникийн инженерийн, Түмэнжаргалын Мэндсайханыг иргэний эрх зүйн, Бадарчийн Соёл-Эрдэнийг иргэний эрх зүйн, Батсэнгээгийн Буянхандыг нефтийн бүтээгдэхүүний инженерийн, Цэдэнбалын Нямбаярыг боловсролын менежментийн, Батсайханы Болормааг гадаад худалдааны менежментийн, Цагаандайгийн Батсүхийг банк, санхүүгийн хяналтын, Доржийн Оюунсүрэнг цахилгаан техникийн инженерийн, Өлзийсүрэнгийн Энхболдыг өнгөт металлургийн инженерийн чиглэлээр тус тус 1998/1999 оны хичээлийн жилээс эхлэн ХБНГУ-ын их, дээд сургуулиудын магистрантурт суралцуулсугай.

2. Гонгор овогтой Байгальмааг мэдээллийн системийн менежментийн чиглэлээр 1997/1998 оны хичээлийн жилээс эхлэн Английн Манчестрийн Технологийн дээд сургуулийн магистрантурт суралцуулсугай.

3. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1997 оны 224/268 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Гадаад орны магистрантурт суралцагчийн зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр хийхийг Сургалтын төрийн сангийн захирал Б.Ганбатад, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Алтангэрэлд тус тус даалгасугай.



САЙД

Ч.ЛХАГВАЖАВ